



№04 (143)

2023 оны 04-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

**“ДЦС-4” ТӨХК ҮҮСЭН
БАЙГУУЛАГДСАНЫ
40 ЖИЛИЙН ОЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХҮРЭЭНД ЗОХИОН
БАЙГУУЛАГДСАН
“ШИЛДЭГ СПОРТЫН
ХАМТ ОЛОН”
ШАЛГАРУУЛАХ
СПОРТЫН НААДМЫН
МЭДЭЭЛЭЛ**

2-7-р нүүрт

**2023 ОНЫ 3-Р
САРЫН ТЭЗҮ**

8-р нүүрт

**2023 ОНЫ 3-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

9-р нүүрт

**3D SOLIDWORKS
ПРОГРАММЫН
СУРГАЛТ**

10-р нүүрт



Сонины
талаарх санал
хүсэлтээ
2125, 2602
дугаарын
утас, sxa@tpp4.mn эсвэл

СХА-нд файлаар болон бичгээр
өгч болно.



www.tpp4.mn/erchim



“ДЦС-4” ТӨХК үүсэн байгуулагдсаны түүхт 40 жилийн ой 2023 онд тохиож байна. Энэ ойн арга хэмжээний хүрээнд томоохон ажлууд зохион байгуулж байгаагийн нэг нь уламжлал болсон компанийн “Шилдэг спортын хамт олон” шалгаруулах 9 төрөлт спортын цогц арга хэмжээ юм. Энэхүү нэрэмжит тэмцээний шатар, даам, ширээний теннис гэсэн 3 төрөлт тэмцээн 3-р сард зохион явагдсан бол 4-р сарын 7-8-ны өдрүүдэд тэмцээний оргил арга хэмжээг Хандгайт дахь “Их тамир спорт цогцолбор”-т сагсан бөмбөг, волейбол, дартс, олс таталт гэсэн 4 төрлөөр амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд давхардсан тоогоор 1400 гаруй тамирчид, үзэгч хөгжөөн дэмжигчид хамрагдсан.

Мөн шагналын сан 8-10 дахин нэмэгдсэн нь 40 жилийн ойн нэрэмжит тэмцээний онцлог байлаа.

Нэгдсэн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаа 4-р сарын 7-ны 13:00 цагаас зохион байгуулагдаж бүх цех, хэлтэс, нэгжүүдийн дарга нар өөрсдийн нэгжийн ажилчдын хамт жагсан, компанийн Гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг нээж үг хэллээ. Нээлтийн үйл ажиллагааг “Мөрөөдлийн театр” хамтлагийн жүжигчин СТА Г.Алтаншагай хөтлөн явуулж, ХЦДБЧ-ийн үндэсний хөгжмийн хамтлаг, VOICE шоуны шилдэг оролцогч, дуучин Б.Одмандах, реппер дуучин У.Мөнхбагана /ROOKIE/ нарын уран бүтээлчид ая дууны дээжээсээ өргөн барьлаа.



Спортын 4 төрөлд эхний гурван байрт шалгарсан багууд:

Төрөл	Ангилал	Алтан медаль	Мөнгөн медаль	Хүрэл медаль
Сагсан бөмбөг	эмэгтэй	П.Баяр–Эрдэнэ даргатай ТДЦ	Захиргаа /хэлтэс/ шигшээ баг	Б.Алтанхуяг даргатай ЦЦ
	эрэгтэй	Б.Алтанхуяг даргатай ЦЦ	Д.Лувсанчүлтэм даргатай ТЦ	П.Баяр–Эрдэнэ даргатай ТДЦ
Волейбол	эмэгтэй	Захиргаа /хэлтэс/ шигшээ баг	Д.Лувсанчүлтэм даргатай ТЦ	Д.Ганболд даргатай ЗЦ
	эрэгтэй	Б.Алтанхуяг даргатай ЦЦ	Б.Батцэрэн даргатай ДХХАЦ	Д.Энхбүрэн даргатай МЦ
Олс таталт		П.Баяр–Эрдэнэ даргатай ТДЦ	Д.Ганболд даргатай ЗЦ	Д.Энхбүрэн даргатай МЦ
Дартс		Б.Батцэрэн даргатай ДХХАЦ	Д.Энхбүрэн даргатай МЦ	П.Баяр–Эрдэнэ даргатай ТДЦ

Үйлдвэрчний эвлэлийн хорооны нэрэмжит шилдэг тоглогч, шилдэг багийн шагналыг дараах тоглогчид хүртлээ. Үүнд:

- » "Волейболын шилдэг эрэгтэй тоглогч" – СдМ ЦЦ–ийн РХА–ийн монтёр М.Өлзийбаяр
- » "Волейболын шилдэг эмэгтэй тоглогч" – ОУХМ ТЦ–ийн турбины машинч Б.Сүнжидмаа
- » "Сагсан бөмбөгийн шилдэг эмэгтэй тоглогч" – ОУХМ ТДЦ–ийн дамжлагын машинч Б.Цацрал

- » "Сагсан бөмбөгийн шилдэг эрэгтэй тоглогч" – ТЦ–ийн ээлжийн дарга Б.Алтанхан
- » Дартсын тусгай байрын шагнал /багаар/ Б.Батцэрэн даргатай ДХХАЦ–ийн 2–р баг
- » Олс таталтын тусгай байрын шагнал /багаар/ Захиргаа /алба/–ны шигшээ баг тус тус шалгарлаа.
- » "Шилдэг хөгжөөн дэмжигч" хамт олноор Д.Энхбүрэн даргатай МЦ–ийн хамт олон шалгарч Нийгэм ахуйн хэлтсийн нэрэмжит шагналаар тус тус шагнагдлаа.



СПОРТЫН НААДМЫН ҮЙЛ ЯВЦААС







I байр – ЗАХИРГАА хэлтэс /волейбол/



I байр – ЦАХИЛГААН ЦЕХ /волейбол/



II байр – ТУРБИН ЦЕХ /волейбол/




II байр – ДХХА ЦЕХ /волейбол/



III байр – ЗУУХАН ЦЕХ /волейбол/



III байр – МЕХАНИК ЦЕХ /волейбол/



I байр – ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХ, II байр – ЗУУХАН ЦЕХ, III байр – МЕХАНИК ЦЕХ /олс таталт/





"ДЦС-4" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг тэмцээнийг хааж үг хэлэхдээ "Цехүүдийн тамирчдын нас залуужсан, өрсөлдөөнтэй, үзүүштэй, зохион байгуулалт сайтай сайхан тэмцээн боллоо" хэмээн дурдаж төрийн дуулал эгшиглэснээр 40 жилийн ойн спортын нэгдсэн арга хэмжээ өндөрлөсөн юм.

Ирэх намрын налгар өдрүүдэд хөлбөмбөг болон



снукер билльардын тэмцээн зохион байгуулагдсанаар 2023 оны "Спортын аварга хамт олон" шалгарах юм.

Тэмцээний хаалтын арга хэмжээний үеэр ЭХС-ийн ширээний теннисний 10 удаагийн аварга, СБХ-ийн нярав Ц.Наранцацралтад ширээний теннисний спортыг түгээн дэлгэрүүлсэн үйлсийг нь үнэлж, Зуухан цехийн хамт олноос дурсгалын зүйл гардууллаа.



ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ТЭМЦЭЭН

Компанийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн 3-р сарын 27-28-ны өдрүүдэд "Эрчим" ширээний теннисний клубт амжилттай зохион байгуулагдлаа. Энэ жил 40 жилийн ойн тэмцээн гэдэг утгаараа ахмад тамирчид болон "ДЦС-4" ТӨХК-д ажил үйлчилгээ явуулдаг туслан гүйцэтгэх компаниуд оролцсоороо онцлог байлаа. Тэмцээнд:

Дан хосын төрөлд /эрэгтэй/

- 1-р байр Н.Алтанзул /ТДЦ, М.Баярсайхан /ахмад тамирчин/
- 2-р байр Х.Зоригт /ДХХАЦ/, Г.Нацагдорж /ахмад тамирин/
- 3-р байр Б.Сосорбарам /ЗЦ/, Д.Загдсүрэн /ЗЦ/

Дан хосын төрөлд /эмэгтэй/

- 1-р байр Б.Ганчимэг /ДХХАЦ/, Ц.Наранцацрал /СБХ/
- 2-р байр Б.Бүрэнжаргал /ХА/, Ж.Болортуяа /ТЭЗХ/



3-р байр Б.Оюунчимэг /ҮА/, А.Бат-Эрдэнэ /ҮА/

Нэг бүрчилсэн /эрэгтэй/

- 1-р байр Б.Сосорбарам /ЗЦ/
- 2-р байр Л.Мягмарсүрэн /СХА/
- 3-р байр Х.Зоригт /ДХХАЦ/

Нэг бүрчилсэн /эмэгтэй/

- 1-р байр Ц.Наранцацрал /СБХ/
- 2-р байр Б.Бүрэнжаргал /ХА/
- 3-р байр Ж.Болортуяа /ТЭЗХ/

Багийн нийлбэр дүнгээр байр эзлүүлэхэд

- 1-р байр Захиргаа /Алба/
- 2-р байр Зуухан цех
- 3-р байр Дулааны хянах хэмжүүр автоматикийн цех шалгарч бусдыгаа хошуучлан амжилттай оролцлоо.





Түүхтэй 40 жилийн ойн нэрэмжийн
спортын наадам

2023
SPORTS DAY

**“КОМПАНИЙН АВАРГА СПОРТЫН ХАМТ ОЛОН” ШАЛГАРУУЛАХ 9 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ
ЭХНИЙ 7 ТӨРӨЛТИЙН УРЬДЧИЛСАН ДҮН**

№	Нэгжийн нэр	Шатар	100 буудалт даам	Ширээнийн теннис	Волейбол	Сагсан бөмбөг	Дартс	Олс таталт	НИЙЛБЭР ДҮН	БАЙР
1	ЗАХИРГАА /АЛБА/	2	5	1	8	8	5	4	33	III
2	ЗАХИРГАА /ХЭЛТЭС/	3	8	4	1	4	9	6	35	IV
3	ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХ	6	2	6	7	1	3	1	26	II
4	ЗУУХАН ЦЕХ	1	1	2	4	5	4	2	19	I
5	ТУРБИН ЦЕХ	5	3	9	6	3	6	5	37	VI
6	ЦАХИЛГААН ЦЕХ	9	4	7	3	2	7	5	37	VI
7	ДУЛААНЫ ХЯНАХ ХЭМЖҮҮР АВТОМАТИКИЙН ЦЕХ	8	6	3	2	9	1	7	36	V
8	ХИМИ ЦЕХ	4	9	8	9	6	8	7	51	VII
9	МЕХАНИК ЦЕХ	7	7	5	5	7	2	3	36	V



2023 ОНЫ 3-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас **9007.690** мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, **1246.658** мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг **7761.032** мян.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал **460** МВт, дээд ачаалал **684** МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	390.1	397.9	7.8	102.0
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	490.2	490.2	0.0	100.0

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **102,0%**, ДЭХ - **100,0%** биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
63	9007.690	20	1684.700	4	1246.658	684	460	7761.032	-

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд **825.374** мян.кВтц буюу **15.6** сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, **155.918** мян.кВтц буюу **5.8** сая.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр **9.8** сая.төгрөгний ашигтай ажиллалаа. Өссөн дүнгээр **16.3** сая.төгрөгийн авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс **18.6** сая.кВтц-аар давуулан **104.9** %-н биелэлттэй, оны эхнээс **49.6** сая.кВтц-аар давуулж, **104.1** % -ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 3-р сартай харьцуулбал **12.9** сая.кВтц буюу **3.27** %-н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт **0.9** мян.Гкал-аар давж **100.2** %-н биелэлттэй, оны эхнээс нийт төлөвлөгөө **24.4** мян.Гкал-аар, үүнээс "УБДС" ХК -д нийлүүлэх дулаан **45.5** мян.Гкал -аар буурч **97.2** %-н биелэлттэй байна. Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 3-р сартай харьцуулбал **9.6** мян.Гкал буюу **1.97** %-н өсөлттэй байна.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд **8** зуух, **7** турбин оролцсон. Сарын дунджаар **6.78** зуух, **6.01** турбинтэй ажиллаж, **0.72** зуух бэлтгэлд, турбин бэлтгэл тоноглолгүй байлаа. К-3 төлөвлөгөөт их засварт, ТГ-7 дунд засварт зогссон.

Мазутын зарцуулалт

Энэ сард **100** тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс **83** тн-г түлж, **17** тн мазут хэмнэсэн. Тайлант хугацаанд 3 удаагийн хүйтэн галлагаанд **64** тн, 1 удаагийн халуун галлагаа хийж **10** тн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар **21** тн мазут зарцуулсан.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	210.000	209.626	-0.374	99.8
Шивээ-Овоо	мян.тн	190.000	190.543	0.543	100.3
Бүгд	мян.тн	400.000	400.169	0.169	100.04

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: **3.515** гр/кВтц-аар, Дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: **1.628** кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс **2197** тонн жишмэл түлш буюу **4642** тонн бодит түлш /илчлэг **3313** ккал/кг/ хэмнэсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ-аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг **0.19** %-иар буюу **866.962** мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	3-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	28.52	28.04
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	4.40	4.33
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	8.13	7.99
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	10.17	10.00
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.60	0.59

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөлтөөс **0.18** % буюу **3695** тн-оор хэмнэж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт **11010** тн нэмэгдсэн байна. Осмосын халаагч уурын зарцуулалт **4729** тн байлаа. Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд: **89916** м³
- Зууханд: **224** м³ ус өгсөн.
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - **14509** м³ байлаа.



2023 ОНЫ 3-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 3-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 9 бүртгэгдсэнээс зуух 5 удаа, турбин 4 удаа зогссон. Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар
1	Зуух	1	1	2	2	1	-	2	2	6	5
2	Турбин	-	1	-	2	1	-	-	1	1	4
	Дүн	1	2	2	4	2	-	2	3	7	9

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ЦЦ-2 /693.0 мян₮/, ТДЦ-1 /2,776.1 мян₮/
- Мазут зарцуулалтын акт: ЦЦ-1 /18,823.3 мян₮/, ЗЦ-2 /96,315.3/
- Тоноглолын аваарийн зогсолтыг судалсан акт: ДХХАЦ-1 /4,043.5 мян₮/
- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: СБХ-2, ЗЦ-1

**бүгд-3 /3,469.1 мян₮/
бүгд-3 /115,138.6 мян₮/
бүгд-1 /4,043.5 мян₮/
бүгд-3**

Нийт 10 ширхэг /122,651.2 мян₮/ акт тогтоогдсон.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °С)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	2022 оны 3-р сар	2023 оны 3-р сар	
1	ТДЦ	78.4	71.1	13.5	12.2	43.4	43.5	17.2	9.94	-7.26 пунктээр буурсан.
2	ЗЦ	82.6	84.5	25.8	22.4	20.3	24.2	10.1	7.11	-3.04 пунктээр буурсан.
3	ТЦ	68.9	81.4	18.2	28.0	13.6	26.4	13.65	8.52	Станцын дундаж тоосролт
4	Хими	52.0	79.2	19.3	22.6	27.5	28.8			
5	Механик	85.7	83.3	21.4	21.8	10.6	19.3			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр


№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	39 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	Цехүүдээр эргэлт хийсэн.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	Эстакадын шугам хоолойн монтажийн ажилд болон ТА №5, зуух №2 -ын засварын ажилд хяналт тавьж ажилласан.

2. Сургалт, зааварчилгаа

1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	150 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	5 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	6 ажилтнаас шалгалт авсан.
4	Бусад сургалтын талаар	100%	Зэрэг ахиж буй 4 ажилтнаас шалгалт авсан.

3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар

1	МХЕГ -ын ХАБУЛ лабораторитой байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	2023 оны 1-р улирлын ээлжит шинжилгээнд: Ундны ус-3 цэгээс, агаар 2 цэгээс, арчдас-10 ш, хоолны илчлэг /нян хими/ нийт 10 порц хоол шинжилгээнд өгөв. Хариу ажлын 14 хоногт гарна.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн 6 цехэд хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийсэн. Стандарт шаардлага хангаагүй ТДЦ, ЗЦ, ТЦ-ийн гэрэлтүүлгийг протокол бичиж ҮА-д өгсөн. ЭЗЦГ-т хөдөлмөрийн нөхцлийн болон гэрэлтүүлгийн 1-р улирлын хэмжилт хийсэн.
3	Ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт тавьсан талаар	100%	Тогтмол хяналт тавин ажиллаж байгаа. Зөрчилгүй ажилласан.
4	Ариутгал халдваргүйтгэл, шавьж мэрэгчийн устгал хийсэн талаар	100%	III/02-нд шавьж мэрэгчийн ээлжит устгал хийв. Хяналт тавьж байгаа
5	Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн /Хэмжилт хийхэд хяналт тавьж ажилласан./



3D SOLIDWORKS ПРОГРАММЫН СУРГАЛТ

Ерөнхий инженерийн санаачлан хэрэгжүүлж буй техникийн шугам зургийн цахим сантай болох, шаардлага хангасан ажлын зургаар эд анги үйлдвэрлэдэг байх зорилтын хүрээнд Судалгаа хөгжлийн албаны ЗБТС-ны хэсгийн Зураг зүйн инженер Л.Мягмарсүрэн компанийн ажиллагсдын дунд "Solidworks" зургийн программын сургалтыг 2023 оны 2-р сарын 13-наас 3-р сарын 30-ныг дуустал амжилттай зохион байгууллаа.

Нэг удаад 10 хүний дүүргэлттэйгээр 9 удаагийн сургалт явуулж, нийт 83 ажилтан хамрагдсан байна. Үүнд: Хяналтын алба – 2, Үйлдвэрлэлийн алба – 1, Судалгаа хөгжлийн алба –

6, Түлш дамжуулах цех – 12, Зуухан цех – 22, Турбин цех – 12, Цахилгаан цех – 16, Дулааны хянах хэмжүүр автомакийн цех – 8, Хими цех – 1, Механик цех – 3 ажилтан тус тус байна.

Сургалтанд хамрагдсан нийт ажилтнууддаа болон сургалт явуулах нөхцөлөөр хангаж өгсөн Захиргаа хүний нөөцийн албаны хамт олонд цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.



СХА-ны ЗБТС-ны хэсгийн
Зураг зүйн инженер
Л.Мягмарсүрэн

